

Хөдөө аж ахуйн хоршоодын удирдлагын тайланд өөрчлөлт оруулах шаардлага, оруулсан өөрчлөлт

Одоо хоршоодоос авч байгаа удирдлагын тайлан 8 чиглэл дотор 256 асуултаас тухайн хоршоо өөрт холбогдохыг хариулж байгаа юм байна. Үндэсний холбооны хувьд гишүүдийнхээ талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй байх шаардлагатай тул тайланд нилээн олон үзүүлэлтийг хамруулсан байна. Харин анхан шатны хоршоод, зарим аймгийн ХААХХ аль болох товч, хялбархан мэдээлэл гаргаж ирүүлэхийг хүсэлт болгож байгаа.

Улс орны хэмжээнд хоршооллын асуудал анхаарал татаж тухайн аж ахуй бүтэц, зохион байгуулалт, мөн чанар, үйл ажиллагааны хувьд хоршоо мөн эсэх, хоршоод нийгэмд ямар үүрэг гүйцэтгэж байгаа, төр засгийн дэмжлэг, оногдуулах үүргийг хариуцаж чадах чадвартай эсэх зэрэг олон мэдээллийг үндэсний холбоо мэдэж байх шаардлага нэмэгдэж байна. Иймд хоршоодоос авдаг удирдлагын тайланг хэт хялбарчлах нь өөрсдийнхөө үнэлэлт, бусдад танигдах боломжийг бууруулж болохыг анхаарах нь зүйтэй.

Аймгуудын хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо, хоршоодоос ирүүлсэн тайлантай нэг бүрчлэн танилцаж тайланг үнэн зөвөөр бүрэн гаргахад ямар материал, ямар хэмжээний цаг хугацаа шаардагдахыг харгалзаж, мөн удирдах зөвлөлийн зарим гишүүдийн санал хүсэлтийг үндэс болгож удирдлагын тайланг хялбарчилж багасгах санал оруулж байна.

Удирдлагын тайлан нийт 8 хэсэгт 60 орчим асуултанд хариулахаар болгож багасгаж байна.

Удирдлагын тайлангийн маягтийг

Бөглөх товч удирдамж

Хоршоодын өмнөх онуудын тайлантай танилцаж үзэхэд олон хоршооны удирдлага энэ асуудалд санаатай болон санамсаргүйгээр хайнга хандсан, тайланг буруу ташаа гаргасан явдал ажиглагдаж байна. Ийм учраас удирдлагын тайланг нөхөхөд анхаарвал зохих зарим товч зааврыг та бүхэнд өгч байна. Үүнд:

Үйл ажиллагааны үр дүнгийн тайланд–Маягт 1

- Нийт зардал гэсэн тооноос
 - Бүтээгдэхүүний үнийн зөрүүд олгосон хөрөнгө мөнгийг Нөөцийн санд хуваарилсан хөрөнгийг сугалж тусгана. Учир нь энэ 2 зардал нь хоршооны мөн чанар, үйл ажиллагааны үр дүнг илтгэх гол үзүүлэлт юм. Мөн ААНОАТ-ын тухай хуулийн 12.1.15 хоршооны болзошгүй алдагдлын нөөц санд төвлөрүүлсэн хөрөнгө зардал болж татвараас чөлөөлөгдөх учиртай.
- Татвар шимтгэл гэсэн хүснэгтэд ААНОАТ, НӨАТ, Гаалийн татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар, эрүүл мэндийн болон НДШ, дундын суутгал мөн бусад суутгалыг нэгтгэж бичнэ.

Үлдэгдэл тэнцэл–Маягт 2

- Өр төлбөрийн дүн гэдэгт хэрэв өр төлбөр байгаа бол урт ба богино хугацаа төрийг хамтатгаж дүнгээр нь бичнэ.

Ажиллагсдын мэдээлэл–Маягт 3

Энд хоршооноос цалин хөлс авч ажилладаг хүмүүсийг бичнэ.

Бүтээгдэхүүн үйлчилгээ-борлуулалтын орлого–Маягт 4

- Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний орлого гэсэн хүснэгтэд хоршооны өөрийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогыг нэр төрлөөр нь 1,2-р хүснэгтэд хоршооны өөрийн аж ахуйн бүтээгдэхүүн болон гишүүдийн бэлтгэсэн бүтээгдэхүүнийг зуучилж хамтран борлуулсан орлогыг хамтатгаж бичнэ.
- Хадгаламж зээлийн үйл ажиллагааны орлого байдаг бол бусад гэдэгт оруулж бичнэ.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл–Маягт 5

Энд зөвхөн тухайн хоршооны өмчлөлд байгаа мал, тариалангийн талбай, хураан авсан ургацыг бичнэ. Гэхдээ бод мал 50 толгойгоос бог мал 500 толгойгоос дээш тоотой бол төрлөөр бичнэ. Харин үржлийн шилмэл омгийн болон эрлийз мал байвал төрөл, хүйсээр нь ялгаж бичнэ.

Санхүүжилтийн эх үүсвэр - Маягт 6

- Энд
1. Өөрийн хөрөнгөөр
 2. бусад эх үүсвэрээр гэсэн 2 ангиллаар бичнэ.

Зохионбайгуулалт–Маягт 7

Нийт гишүүд үүнээс тухайн жилд шинээр элссэн, мөн нийт эмэгтэй гишүүдийн тоог сугалж бичнэ.

Анкет–Маягт 8

Энд зөвхөн тухайн жилд шинээр байгуулагдсан хоршооны дарга, ня-бо мөн шинээр сонгогдсон дарга, ня-бо-ийн анкетыг бичнэ.